

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

/2016 оны жилийн эцэс/

Д/д	Дугаар	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2016 онд хүрэх түвшин, үр дүн	2016 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/	Хэрэгжилт	Биелэлт гаргах нэгж	Биелэлт гаргасан мэргэжилтэн	ХШҮДАГ Үнэлгээ
1	2	3	4	5	6	7				
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>										
<b>Зорилт 2. Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>										
1	2.1	ҮХЦБ-ын 5.1.5, 2.2.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 28 дахь заалт	Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум ам.доллар	1.8	-	Засгийн газрын 2015 оны 511 тогтоолыг батлуулан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэн. Энэ ажлын үр дүнд 2016 оны жилийн эцсийн байдлаар геологи хайгуулын салбарт гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан тусгай зөвшөөрөл 393 болж өсөөд байна. 2015 оны жилийн эцсийн мэдээгээр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж 98,890,953,086 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. /2016 хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтын нэгтгэл 2017 оны эхний хагаст гарна./	ГБГ	Д.Болортуяа	100
2	2.4	ЗГҮАХХАХТ-ний 51.1 дэх заалт, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид “ТЭБСББ” гэх/-ын 3.3.2 дахь заалт	Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Ажлын явц, хувиар	20-иос дээш	-	Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг явуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан ба төслийн 2 дахь шатны ажлыг эхлүүлж, туслан гүйцэтгэгч “РедПат” ХХК-д 230 дугаартай тэсэлгээний тусгай зөвшөөрлийг Уул уурхайн сайдын /хуучнаар/ 2016.05.20-ны өдрийн А/54-р тушаалаар шинэчлэн олгож шийдвэрлэсэн. Далд уурхайн ажил графикайн дагуу явагдаж байна. Одоогийн байдлаар далд уурхайн бүтээн байгуулалтын ажил эхлээд байгаа бөгөөд эхний ээлжинд Хойд Хюго ордын ашиглалтын 1-р давхрын ажлыг гүйцэтгэж тус бүр нь 1200-1400 метрийн гүнтэй 5 босоо амыг нэвтэрч далд уурхайд байрлуулах 2 бутлуурыг суурилуулж газрын гадарга руу хүдэр зөөх конвейер бүхий налуу ам, 200 км урттай хэвтээ малталтын тунелийг нэвтэрч газрын гадарга дээрх холбогдох дэд бүтцийн ажил тухайлбал ус, дулаан,	УУБГ	Б.Бямбарагчаа	90

						цахилгаан хангамж, ажиллагсдын кемпийг байгуулах ажлыг гүйцэтгэх юм. Оюу толгойн 2015 оны ТЭЗҮ-ийг шинэчлэн 2015 оны наймдугаар сард Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүлээлгэж өгч гүний уурхайн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил, ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалтын тооцоог шинэчлэх ажил эхэлсэн ба 2016 оны нэгдүгээр улиралд хөрөнгө оруулалтын шинэчилсэн тооцоог хийж дууссан.			
3	2.5	ЗГҮАХХАХТ-ний 52 дахь заалт	Таван толгойн төслийг үргэлжлүүлэх	Ажлын явц, хувиар	20.0 –иос дээш	- Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах 3 хувилбар бүхий санал боловруулж ордыг олон улсын консерциумтай хамтарсан хэлбэрээр ашиглах нь оновчтой гэсэн санал дээр тогтож нэгэнт бий болсон үйлдвэр, дэд бүтцийг шууд ашиглах, Хятадын зах зээлд нэвтэрч бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн ханшаар борлуулах, гуравдагч зах зээлд гарах боломж бүрдэх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, урьд хийсэн яриа хэлэлцээг үр дүнд хүргэх боломжтой гэж үзсэн. Тавантолгойн ордыг дэд бүтцийн хамт иж бүрнээр нь ашиглалтад оруулах талаар хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулах Ажлын хэсэг нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2016.11.16-ний өдрийн 104-р захирамжаар шинээр байгуулагдан хэлэлцээр хийгдэж байна. Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглахтай холбогдон, Уул уурхайн яам /хуучнаар/ /Эрдэнэс тавантолгой ХК/ болон Япон улсын НЕДО байгууллага /Нагата инженеринг/ хамтран Тавантолгойн ордыг түшиглэн нүүрсийг хуурай аргаар баяжуулах туршилтын үйлдвэр байгуулах тухай санамж бичгийг байгуулсан ба уг төслийн ажлыг тус яам үргэлжлүүлж байна. Таван толгойн ордын Зүүн цанхийн хэсэгт оператор компаниар ажиллах сонгон шалгаруулалтад Австралийн Макмахон, Германы Оперта компаниудын нэгдэл шалгарсан боловч Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Макмахон Монголиа ХХК-тай 2011 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бөгөөд 2012 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эрх шилжүүлэх гэрээ байгуулж, ТиТиЖэйВиСиКөү ХХК-д хамтын ажиллагааны гэрээгээр эдлэх эрх, үүргээ шилжүүлсэн. 2016 оны 12 сарын 07-ны өдөр Японы НЕДО байгууллага, Нагата инженеринг компанийн төлөөллийг хүлээн авч уулзан, санамж бичгийн талаар	УУБГ	Б.Бямбарагчаа	70

						болон төслийн явцын талаар харилцан санал солилцон цаашдын хамтын ажиллагааны талаар санал, албан тоотыг НЕДО руу хүргүүлэв. Төслийн үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх талаарх хууль эрхзүйн орчны судалгааг хийж Сангийн яам болон Татварын ерөнхий газарт санал боловруулж хүргүүлэхээр бэлтгэсэн.				
<b>ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО</b>										
<b>Зорилт 5. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.</b>										
4	5.1	ЗГҮАХХАХТ-ний 99.1 дэх заалт	Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100.0	14.0 Хувийн хэвшил , Гадаад эх үүсвэр	“Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-аас 2015 оны 113-р тогтоолоор баталсан “Жилд 2 сая хүртэл тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Говийн бүсэд, гурван зуун мянган тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Зүүн бүсэд байгуулах <b>урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл</b> боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх”-ээр заасны дагуу “Говийн бүсэд газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2015 оны <b>05 сараас 2016 оны 04 сар хүртэлх</b> хугацаанд Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ зохион байгуулсан. <b>ТЭЗҮ боловсруулах төсөв 1,5 төгрөгийг “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас санхүүжүүлсэн.</b> Уг тендэрт шалгарсан Бүгд Найрамдах Унгар Улсын “Евройл” компани урьдчилсан ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэн эцсийн тайлан <b>/7 боть/-г</b> 2016 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн бөгөөд урьдчилсан ТЭЗҮ-ийг ЗГ-т танилцуулснаар “Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” <b>ЗГ-ын 2016.02.08-ны өдрийн 75-р тогтоол батлагдсан.</b> Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Говийн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх Үндэсний компани (ууд)-ийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалт”-ыг зарлах шийдвэрийг Аж үйлдвэрийн сайдын /хуучнаар/ 2016.04.06-ны өдрийн 59-р тушаал гарсан. Уг уралдаант шалгаруулалтад үндэсний болон олон улсын компаниуд хамтарсан нийт 4 консорциум материал ирүүлсэн бөгөөд материалыг 2016.05.13-ны өдөр хүлээж авахаар төлөвлөж байсан боловч уралдаант шалгаруулалтын	ХҮБГ	Ц.Тэмүүжин	100

						оролцогч консорциумын гишүүн “Интер стандарт нефть” ХХК-иас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаснаар сонгон шалгаруулалт явагдаагүй.			
5	5.2	ЗГҮАХХАХТ-ний 49.3 дахь заалт	Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	- Энэхүү ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын “Volant Industry” компани болон Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төсөл боловсруулах институт /ENFI/ “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) боловсруулсан ба уг ТЭЗҮ-ийг Аж үйлдвэрийн салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх олгох тухай” ЗГ-ын 2016 оны 318-р тогтоол батлуулсан. Уг тогтоолоор “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нийт хувьцааны” 10 (арван) хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших тухай Аж үйлдвэрийн яамны /хуучнаар/ саналыг зарчмын хувьд зөвшөөрч, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх, мөн хөрөнгө оруулагчийг сонгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг тус яаманд даалгасан.	ХҮБГ	Ц.Тэмүүжин	70
6	5.3	ЗГҮАХХАХТ-ний 103 дахь заалт	Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	- Уул уурхайн сайдын /хуучнаар/ 2016.05.16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар Монгол Японы ЗГ хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд нүүрсийг байгаль орчинд халгүй технологиор үр дүнтэй ашиглах, боловсруулах, Япон улсын технологийг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор тус улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах Ажлын хэсгийг төр хувийн хэвшлийн хамтарсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. ЗГ-ын захиалгаар Дэлхийн банкны хөнгөлттэй зээлийн санхүүжилтээр “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх мөн тус төслийн “Байгаль орчин, нийгмэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний ажлыг гүйцэтгэх олон улсын нээлттэй тендерийг 2015 оны 4 дүгээр сард зохион байгуулсан. Уг тендерт ”БНХАУ-ын “Wuhuan Engineering Co., Ltd” компани болон туслан гүйцэтгэгчээр Монгол Улын	ХҮБГ	Ц.Тэмүүжин	70

					<p>“Гранд Повер” компаниуд “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөхөөр, тус төслийн “Байгаль орчин, нийгмэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний ажлыг гүйцэтгэх зөвлөхөөр Монгол Улсын “Грийн трендс” компаниуд шалгарч Аж үйлдвэрийн яам /хуучнаар/, Дэлхийн банкны Уул, уурхайн дэд бүтэцийг дэмжих төсөлтэй 2016.03.23-ны өдөр ажил гүйцэтгэх гурвалсан гэрээг байгуулсан.</p> <p>Дээрх гэрээнд тусгаснаар төслийн зөвлөх үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Wuhuan Engineering” компаниас 2017 оны 01 дүгээр сард “Байгалийн хийн зах зээл, үйлдвэрийн хүчин чадлын судалгаа”, “Нүүрсний уурхайн сонголтын тайлан”, “Усны нөөцийн судалгааны тайлан”, “Шугам хоолойн трассын сонголтын урьдчилсан тайлан”, “Тусгай судалгааны тайлан, “Нүүрс хийжүүлэх технологийн харьцуулсан судалгаа”, “Метанжуулах технологийн харьцуулсан судалгаа”-ны тайлангуудыг, “Green trend” компаниас “Бүс нутгын байгаль, орчны үнэлгээний урьдчилсан тайлан”-г ирүүлээд байна.</p> <p>Засгийн газраас 2016 онд баталсан 107-р тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар шийдвэрлэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016.10.21-ний өдрийн А/43-р тушаалаар Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн нэгжийг байгуулан ажиллаж байна.</p> <p>Энэхүү төсөл хэрэгжүүлэх нэгж нь нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, хий дамжуулах хоолойн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллах бөгөөд үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг 2017 оны 4 дүгээр сард, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний эцсийн тайланг 2017 оны 5 дугаар сард Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компаниудаас тус тус ажлын явцад хяналт тавин хүлээн авахаар ажиллаж байна.</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

7	5.7	ЗГҮАХХҮАТ-ний 103.1 дэх заалт	Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 10 дугаар сард БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Уул уурхайн яам болон БНХАУ-ын Синопек корпорацийн хооронд “Монгол Улсад нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төсөл хэрэгжүүлэх тухай” санамж бичиг байгуулсан. 2014-2015 оны хооронд БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран Монгол Улсын зүүн бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн нүүрснээс синтетик байгалийн хийн үйлдвэр байгуулах, хий экспортлох төслийн урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/-ийг боловсруулсан. Төслийн хүрээнд жилд 8 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх 2 үйлдвэрийг Цайдамнуурын болон Эрдэнэцогтын ордуудыг түшиглэн байгуулах бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор Эрдэнэцогт болон Цайдам нуурын нүүрсний ордуудад жилд 80 сая тонн нүүрс олборлох нүүрсний ил уурхай байгуулагдаж, хийн үйлдвэрүүд нь 50 жилийн туршид жилд 16 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх боломжтой.</p> <p>Энэхүү төслийн ерөнхий гүйцэтгэгчээр Синопек корпорацийг толгойлж, хөрөнгө оруулалтын СИС, Хопу сангууд хамтран оролцох тухай албан ёсны хариуг БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос Уул уурхайн яаманд ирүүлсэн. Тус саналд БНХАУ-ын тал 33/33/34 хувиар хувь эзэмших, Монголын тал тодорхой уул уурхайн ордуудыг барьцаалан зээл авах хэлбэрээр хөрөнгө оруулалт гаргах саналыг тавьсан.</p> <p>Монголын тал БНХАУ-ын саналыг судлан үзэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /цаашид “ҮАБЗ” гэх/-өөр хэлэлцүүлсэний дараа ҮАБЗ-ийн 2014 оны 8 дугаар сарын 18-ны өдөр гаргасан зөвлөмжийн дагуу “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл” хэрэгжүүлэх Монгол ба Хятадын хамтарсан компанид уг гэрээний талууд ижил тэнцүү хувь оролцоотой байх, хийн болон ус дамжуулах хоолойн дэд бүтцийг Монголын төр 100 хувь эзэмших зарчмаар ажиллахыг чиглэл болгосон. Монголын талын энэ саналыг БНХАУ-ын тал хүлээн авах боломжгүй гэж уулзалт ярилцлагадаа удаа дараа тэмдэглэж, хамтран ажиллах гэрээний өөр хувилбаруудыг судалж үзэхээр 2 тал тохиролцсон.</p>	ХҮБГ	Ц.Тэмүүжин	90
---	-----	-------------------------------	---	---------------------------------------	-------	---	------	------------	----

						<p>2015 оны 11 сард Синопек корпорацийн удирлага солигдсоноор энэхүү төслийг үргэлжлүүлэх боломжгүй талаар БНХАУ-ын тал мэдэгдэж Засгийн газрын 2016 оны 2 сарын 26-ны өдрийн 131-р тушаалаар төслийн нэгжийг татан буулгасан.</p> <p>Мөн Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамнаас 2016 оны 3 дугаар сард Монгол Улсын Уул уурхайн яам/хуучнаар/, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамтай хамтран “Цэвэр нүүрсний технологи” семинарыг зохион байгуулсны зэрэгцээ энэ оны 06 дугаар сард “Цэвэр нүүрсний салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийг тус тус байгуулсан. Цаашид нүүрс-химийн аж үйлдвэрийн үндэс суурийг Монгол улсад тавьж хөгжүүлэх зорилгоор нүүрс химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний судалгаа”-ны ажлыг Япон улстай хамтран хэрэгжүүлэх санал боловсруулж тус улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Мөн Уул уурхайн сайдын /хуучнаар/ 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар Монгол Японы Засгийн газар хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд нүүрсийг байгаль орчинд халгүй технологиор үр дүнтэй ашиглах, боловсруулах, Япон улсын технологийг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор тус улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах Ажлын хэсгийг төр хувийн хэвшлийн хамтарсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.</p>				
8	5.8	ЗГҮАХХҮАТ-ний 67.10 дахь заалт	Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	Уг асуудлыг ЭХЯ толгойлон ажиллаж байгаа бөгөөд Хэлэлцээр хийх ажлын хэсэг байгуулагдсан тохиолдолд манай яамны төлөөлөл оролцож ажиллахаар төлөвлөж байна.	УУБГ	Б.Бямбарагчаа	/-/
<p><b>Зорилт 7.Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.</b></p>										

9	7.5	ЗГҮАХХАХТ-ний 67.10 дахь заалт	Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хангах зорилгоор Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	Хүчин чадлын нэмэгдэх хэмжээ	2 дахин	<p>Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн технологийн шинэчлэлд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал авч нэгтгэсэн. Тогтоолын төслийг холбогдох материалын хамт Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу хариуцсан чиг үүргийн Сангийн яаманд уламжлан хүргүүлсэн. Сангийн яамнаас уг тогтоолын төслийг Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Засгийн газрын 219 дүгээр тогтоолоор батлуулсан. ЭХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд Шивээ-Овоогийн уурхайг түшиглэн шинэ ДЦС байгуулах, уурхайн хүчин чадлыг өргөтгөх, ус хангамжийн судалгааны ажлыг “Шивээ Энержи” ХХК гүйцэтгэж байна.</p> <p>Багануурын уурхайг түшиглэн байгуулах 700 мВт-ын хүчин чадалтай Цахилгаан станцын төсөл болон нүүрс шингэрүүлэх, хийжүүлэх төсөлтэй уялдан уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх ТЭЗҮ-г 2016 оны 6 дугаар сард ЭБМЗ-өөр хэлэлцэж баталсан.</p> <p>АНУ-ын “Norwest”, Монголын “Эрдгео” компанийн хамтарсан консорциум геологи хайгуулын ажлыг 2014 онд хийж, Багануурын уурхайн нүүрсний нөөцийг 274 сая тонноор өсгөж, 812 сая тонн гэж тооцсон. Энэхүү нөөцөд тулгуурлан “RungePincocKMinarco”, “Балчулуу” дээрх уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-ийг боловсруулахдаа Багануурын уурхайн хүчин чадлыг 2018 онд 6.5, 2019 онд 8 сая тонн, 2020 онд 10 сая тоннд хүргэн нэмэгдүүлж, ил уурхайн эцсийн гүнийг 300 метр хүртэл ашиглалт явуулахаар тооцоолсон байна. “ДЦС-3”-ыг 250 мВт, “ДЦС-4”-ыг тодорхой хэмжээгээр өргөтгөх, Багануур дүүрэгт 700 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих тул нүүрсний эрэлт цаашид нэмэгдэх юм. Түүнчлэн Багануурын уурхайг түшиглэн хагас кокс болон хийжүүлэх, нүүрс шингэрүүлэх үйлдвэр барихаар төлөвлөсөн агаад эдгээрт жилд 1-2 сая тонн нүүрс ашиглах аж. Тодруулбал, нийслэлийн ДЦС-уудад 5 сая тонн, Багануурт барих ДЦС-д 3 сая тонн, нүүрс хийжүүлэх үйлдвэрт 2 сая тонн нийлүүлэх уурхай болгон хүчин чадлыг өсгөх юм.</p> <p>- “Шивээ-Овоо”-гийн нүүрсний уурхайг түшиглэн 9240 Мвт-ын дэвшилтэт технологи бүхий агаарын</p>	УУБГ	Б.Бямбарагчаа	70
---	-----	--------------------------------	---	------------------------------	---------	---	------	---------------	----



							хөргөлттэй цахилгаан станц, 8 сая киловатт хэмжээний цахилгаан дамжуулах 800 Кв-ын тогтмол гүйдэлтэй цахилгаан дамжуулах шугам бүхий “Шивээ Энержи” цогцолбор төслийг хэрэгжүүлсэнээр тус нүүрсний уурхайгаас жилд 34 сая.тн нүүрс худалдан авна гэсэн урьдчилсан тооцоо байгаа, үүнтэй холбоотойгоор, орд геологийн нарийвчилсан тооцоо, уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгаа хийж Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил явагдаж байна.			
<b>Зорилт 9.Геологи, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>										
10	9.1	ҮХЦБ-ын 5.2.1.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 38.1 дэх заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	40.0	10.0 Улсын төсөв	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлаар нутаг дэвсгэрийн 40%-ийг хамруулах зорилтын хүрээнд 2016 онд 26 төслийг үргэлжлүүлэн, 10 төслийг шинээр хэрэгжүүлсэнээр нутаг дэвсгэрийн 6%-д төсөл хэрэгжиж 40%-ийг хамруулаад байгаа юм. Эдгээр ажлын үр дүнг авч үзвэл: -2013-2015, 2013-2016, 2014-2016, 2014-2018 онд хэрэгжиж байгаа 26 төсөл, 2016 оноос шинээр хэрэгжүүлэх 10 төслийн ажлын төлөвлөгөө, төсвийг УУС-ын 2016 оны А/38, УУХҮС-ын 2016 оны төслүүдийн төсөвт тодотгол хийх тухай А/75 дугаар тушаалыг батлуулан төсвийг бүрэн зарцуулсан. -2013-2015 онд хэрэгжиж дууссан Тогоо хайрхан-50, Баяндалай-50, Улаанбадрах-50, Онц уул-50, Эмээлцэгийн нуруу-50 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж, УУС-ын 2016 оны А/51, А/62, УУХҮС-ын 2016 оны 17, 18, 19 дүгээр тушаалаар хүлээн авч шийдвэрлэсэн. -Төслүүдийн 2016 оны хээрийн судалгааны ажил болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналтыг хийж зөвлөмж өгсөн ба хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын анхдагч материалыг хүлээн авсан. - БНЧех Улстай хамтарсан геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн “Монгол Алтай-50” төслийн эцсийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн хүлээн авсан.	ГБГ	Х.Санчигдорж	90
11	9.2	ЗГҮАХХАХТ-ний 100.1, 100.2 дахь заалт, Төрөөс газрын тосны салбарт	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн		50.0	19.0 ТХХТ	Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг найдвартай, тасралтгүй болгох, үнийн өсөлтийг сааруулах зорилго бүхий УИХ-ын 2008 оны	ТБЗГ	Д.Дөлгөөн	70

		2017 он хүртэл баримтлах бодлого 3.5.7 дахь заалт	тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх	Барилгын ажлын явц, хувиар			48 тоот “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүнийг нөөц хэлбэрээр байршуулах, нөөцийг хадгалахад нэмж шаардагдах сав барих ажлыг зохион байгуулах асуудал тусгагдсан. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх үүднээс ЗГ-ын 2015 оны 119 дүгээр тогтоолоор Рашаант дах улсын нөөцийн агуулах төслийг концессоор хэрэгжүүлэхээр тогтоосон ба уг тогтоолын 2 дугаар заалт, Рашаант дах улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээний 2.2.1 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Уул уурхайн яам /хуучин нэрээр/, Сангийн яам, төсөл хэрэгжүүлэгч Нэйшнл Трейдинг Энд Транспорт Групп ХХК-ийн хооронд “Улсын нөөцийн шатахуун хагдалах, хадгалуулах, түүнд хяналт тавих гэрээ”-г байгуулсан. Өнөөгийн байдлаар “Нэйшнл Трейдинг Энд Транспорт Групп” ХХК нь “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл”-ийн санхүүжилтыг босгох ажлын хүрээнд төслийн эхний жилийн санхүүжилт болох 16.5 сая ам.долларыг Швецарийн “UBS” банкаас татах, үндсэн 85%-ийн санхүүжилт болох 47 сая ам.долларыг БНЧУ-ын EGAP-ийн даатгалтайгаар тус улсын CSOB болон Ceska Sportelna банкуудаас татахаар хэлэлцэн шийдэлд хүрээд буй талаар мэдэгдэж, Монгол улсын хөгжлийн банкаар дамжуулан тус санхүүжилтыг татах зөвшөөрөл олгох тухай ЗГ-ын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 39 дугаар тогтоолын хүрээнд тус банктай хамтран ажиллаж байна.			
12	9.3	ТЭБСББ-ын 3.3.3 дахь заалт	Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх	Ашиглалтад оруулах ордын тоо	25.0-аас доошгүй	-	-Оюутолгой, Тавантолгой, Цагаансуварга, Гацуурт зэрэг стратегийн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал: - Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт буюу төслийн 2 дахь шатны ажлыг эхлүүлж, туслан гүйцэтгэгч “РедПаг” ХХК-д гэсэлгээний тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. - Цагаансуваргын ордыг ашиглалтад оруулахад шаардлагатай цахилгаан хангамжийн асуудлаар ЭХЯ, холбогдох байгууллагатай хамтран ажилласан. -Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах 3 хувилбар бүхий санал боловсруулж ордыг	БХЗГ	Б.Хулан	90

						<p>олон улсын консерциумтай хамтарсан хэлбэрээр ашиглах нь оновчтой гэсэн санал дээр тогтож нэгэнт бий болсон үйлдвэр, дэд бүтцийг шууд ашиглах, Хятадын зах зээлд нэвтэрч бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн ханшаар борлуулах, гуравдагч зах зээлд гарах боломж бүрдэх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, урьд хийсэн яриа хэлэлцээг үр дүнд хүргэх боломжтой гэж үзсэн.</p> <p>-Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглахтай холбогдон, Уул уурхайн яам /хуучнаар/, Эрдэнэс тавантолгой ХК болон Япон улсын НЕДО байгууллага /Нагата инженеринг/ хамтран Тавантолгойн ордыг түшиглэн нүүрсийг хуурай аргаар баяжуулах туршилтын үйлдвэр байгуулах тухай санамж бичгийг байгуулж төслийн ажлыг эхлүүлээд байна. Японы Нагата Инженеринг компанитай хамтран Эрдэнэс Тавантолгойн уурхайн нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтыг хийлгэсэн. Яам болон уг төслийг хэрэгжүүлж буй Эрдэнэс монгол ХХК хооронд хамтран ажиллах гэрээг байгуулав. 2016 оны 12 сарын 07-ны өдөр Японы НЕДО байгууллага, Нагата инженеринг компанийн төлөөллийг хүлээн авч уулзан, санамж бичгийн талаар болон төслийн явцын талаар харилцан санал солилцон цаашдын хамтын ажиллагааны талаар санал, албан тоотыг НЕДО руу хүргүүлэв. Төслийн үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх талаарх хууль эрхзүйн орчны судалгааг хийж Сангийн яам болон Татварын ерөнхий газарт санал боловруулж хүргүүлэхээр бэлтгэсэн.</p> <p>-Гацууртын ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголд шүүмж дүгнэлт гаргаж ордын нөөцийн ангиллыг шинэчлэн тогтоосноор ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх боломжтой гэж үзсэн. ТЭЗҮ-ийг хэлэлцэж хүлээж авсны дараа Орд ашиглах гэрээ байгуулах талаар яриа хэлэлцээрийг эхлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>- Ашиглахад бэлэн болсон уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс ажлууллагаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс бичиг баримтын бүрдэл хангасан 21 уурхайд Улсын комисс ажилласан.</p>			
13	ЗГҮАХ-ийн 40.12 дахь заалт	Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах	Шинээр мөрдүүлэх үндэсний	9	-	БОНХЯ-аас боловсруулж ирүүлсэн, уул уурхайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн стандартын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн.	УУБГ	Б.Бямбарагчаа	70

	9.4		технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх	стандартын тоо			Стандартчилал хэмжилзүйн газарт уул уурхайн стандартуудыг судалж Евростандартад нийцүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх саналыг хүргүүлсэн. Уул уурхайн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан 2016 оны 12 сарын 26-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүйн сайдаар батлуулсан бөгөөд хуулийн төслийн эхний драфтыг боловсруулаад байна. Уг хуулиар Олон улсын жишигт нийцсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах, хаалтын санхүүгийн баталгаа гаргах зохицуулалтыг хуульчилж өгснөөр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.			
				Шинээр нэвтрүүлэх олон улсын стандартын тоо	1		2016 оны 1 дүгээр сарын 12-ны А/14 тоот Ил уурхай дэд бүтцийн төслөөс Байгаль орчинд учруулсан хохирлыг тооцох түр аргачлал батлагдсан. Тус аргачлалын туршилтын хугацаанд Байгаль орчны хохирол тооцох “амьдрах орчны үнэлгээний аргачлал”-ыг ашиглах гарын авлага БОНХАЖЯ-наас хэвлэгдэн гарсантай холбогдон сургалт, уулзалтанд хамрагдан ажиллалаа. Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр менежментийн тогтолцооны OHSAS 18001, ISO 14001, ISO 90018 ISO 22000 зэрэг олон улсын стандартыг нутагшуулах чиглэлээр НХХЯ, холбогдох төрийн байгууллагууд болон Монголын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн инженерүүдийн холбоо, энэ чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж, сургалт зохион байгуулдаг төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг хийж байна. Үүнтэй холбогдуулан жил бүр “Нэн түрүүнд ХАБ” нэртэй үндэсний зөвлөлгөөн зохион байгуулахад тус яам дэмжигч, хамтран зохион байгуулагчаар оролцож байна.	УУБГ	Б.Бямбарагчаа	70
14	9.5	ЗГҮАХХҮАТ-ний 60.1 дэх заалт	Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгэх ажлыг эрчимжүүлж, орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд холбогдох арга хэмжээ, зардлын төсвийг тусгуулж байна. Аж ахуйн нэгжүүд холбогдох хуулийн дагуу БОАЖЯ-ны	БХЗГ	Б.Хулан	100

						<p>тусгай санд Байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг байршуулж байна.</p> <p>2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар ашигт малтмалын 3672 тусгай зөвшөөрөл эзэмшигч 14,4 сая га талбайд үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 9,2 хувийг эзэлж байна. Үүнээс ашиглалтын 1567 тусгай зөвшөөрөл бүхий 0,9 хувь, хайгуулын 2105 тусгай зөвшөөрөл бүхий 8,3 хувь байна.</p> <p>2016 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд уул уурхайн хайгуул олборлолтын үйл ажиллагааны улмаас 27068 га талбай эвдрэлд орж, үүнээс үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн эвдрэлд оруулсан талбай 20065 га, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай нь 11375 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 7425 га байна.</p>				
<b>ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО</b>										
<b>Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.</b>										
15	12.8	ҮХЦБ-ын 5.3.2 дахь заалт ЗГҮАХХҮАТ-ний 100 дахь заалт	Эрчим хүч, авто бензин, дизелийн түлшний үнийг Монгол Улсын хэмжээнд ижил байх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Алслагдсан аймаг сум, орон нутаг дах шатахууны жижиглэнгийн үнийг Улаанбаатар хотын үнэтэй ойролцоо төвшинд хүргэх ажлыг тус яам тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2015 оноос гадаад зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний үнэ буурсантай холбоотойгоор ЗГ-ын 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 438 дугаар тогтоолоор автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг тонн тутамд Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг боомтуудаар А-80 болон Аи-92 автобензинд 400,000 төгрөг, дизель түлшинд 520,000 төгрөг, Эрэнцав боомтоор А-80 болон Аи-92 автобензинд 270,000 төгрөг, дизель түлшинд 290,000 төгрөг, мөн бусад боомтын татварыг 0 /тэг/ болгон бүсчилж ялгавартай тогтоосон. Үүний үр дүнд 2016 оны нэгдүгээр улиралд шатахууны үнийг төрөл тутамд баруун бүсэд 80-400 төгрөгөөр, зүүн бүсэд 10-230 төгрөгөөр тус тус бууруулсан ба Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Архангай зэрэг аймгуудад шатахууны үнэ 100-150 төгрөгөөр буурсан бол 2016 оны 1 дүгээр сараас Улаанбаатар хотод шатахууны үнэ төрөл тутамдаа 80-150 төгрөгөөр буурч Монгол улсын хэмжээнд авто бензин, дизель түлшний үнийг ижил төвшинд хүргэсэн. Гэвч 2016 оны 07 дугаар сараас төгрөгийн	ТБЗГ	Д.Дөлгөөн	100

						<p>ханш огцом суларсан, Монголбанкны бодлогын хүү нэмэгдсэн, шатахууны импорт /хил/-ын үнэ өссөн зэрэг хүчин зүйлс хавсран шатахууны жижиглэнгийн үнэд сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн тул импортлогч аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн холбоодоос шуурхай арга хэмжээ авах, татварыг бууруулах замаар зохицуулалтыг хийж өгнө үү гэсэн хүсэлт удаа дараа ирүүлсэн. Уг хүсэлтийн дагуу судалгаа тооцоо хийн, ЗГ-ын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолоор байгуулагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн анхдугаар хуралдааныг 09 дүгээр сарын 30-ны өдөр, хоёрдугаар хуралдааныг 11 дүгээр сарын 23-ны өдөр тус тус хуралдуулж холбогдох “Зөвлөмж”-ийг ЗГ-т хүргүүлсэн. Үүний үр дүнд ЗГ-ын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 109 дүгээр тогтоол, 11 дүгээр сарын 30-ны өдрийн 166 дугаар тогтоолоор тус тус автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг тодорхой хэмжээгээр бууруулан дотоодод борлуулж буй шатахууны жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах арга хэмжээ аваад байна.</p>			
		<b>Нийт үнэлгээ</b>							<b>84.2</b>

-----oOo-----

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР